

HISTORIA MONGOLARUM
МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг

ТОМ. XIX

FASC. 1

ЛУНЧЭН (龍城, LONGCHENG) ХЭМЭЭХ ХҮННҮ ҮГИЙН ТУХАЙ

Б.Батсүрэн
МУИС-ийн Түүхийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

Товч агуулга: Хүннү гүрний улс төрийн төв – хэзээ, хэдийд, хаана хаана байрлаж байсныг нарийн шинжилж магадлан тогтоох нь тун чухал, ямагт маш их анхаарал, болгоомжлол шаардах чимхлүүр судалгаа бөлгөө. Эдгээрээс нэн тэргүүнд анхаарвал зохих нь Хүннүгийн улс төрийн төвийг үнэхээр Лунчэн гэж нэрлэж байсан уу үгүй юу гэдгийг тогтоох нь маш чухал хэмээн үзэж өөрсдийн оролдлогоо эл бяцхан өгүүллээр танилцуулахыг хүслээ.

Түлхүүр үг: Хүннү, хүннү үг, лунчэн/лунцы, хурал/хуралдай

Уг нь аль эрт Н.Я.Бичурин, *лунчэн* болон хүннүгийн шаньюй нарын өргөөлөн суух ордон¹ хоёрыг хольж хутгах ёсгүй тусдаа гэж ойлгогдохоор ялгаж орчуулжээ.

Орчин цагийн монголчууд бидний ихэвчлэн *Луут* хот гэж буулгаад байгаа лунчэн гэх галиг үг ямар *жинхэнэ хүннү* үг болохыг тодруулахын тулд, *хүннүчүүдийн* ямар үйлдлийг *ханьгийхан* ийн нэрлэж байсныг юуны өмнө тодорхойлох ёстой гэсэн аргаар асуудалд хандахыг бид оролдов. Тэгэхдээ, лунчэн гэж юуг хэлдэг талаар эрдэмтдээс дэвшүүлсэн санал, таамаглалаас эхлээд өгүүлэх нь зүйтэй болов уу.

Түүхийн тэмдэглэлийн мэдээг Г.Сүхбаатар бага сага ялгаатай буулгажээ. 1968 онд «тавдугаар сард Лунчэнд цөм цугларч өвөг, тэнгэр, газар, савдаг тахьдаг» гэсэн бол 1980 онд «тавдугаар сард Луу хотод их хуралдаанд цугларч, өвгөд, тэнгэр, дэлхий, онгон, хайрхдад (гуйшэнь, 鬼神, guishen) тахилга үйлдэнэ» хэмээн, харин 1992 онд «тавдугаар сард Луу сууринд их хуралдайд цугларч, өвгөд, тэнгэр, дэлхий, онгон, хайрхдад тахилга үйлдэнэ» тус тус хөрвүүлжээ.²

Харин *лунчэн*-ийг 1980 онд «хүннү нарын тахилга хийдэг гол газар нь Луу хот ... миний бодоход Луу хот нь хайрхад байна. [Өөрөөр хэлбэл] «луу хот» гэдэг нь бөө мөргөлийн тахилгын газар, ордонтой том суурин ... Хүннү улс нийтээрээ тахидаг хайрхад бай[жээ]. Х.Пэрлээгийн шинжилсэнээр монголын бөөгийн яруу найрагт гардаг хүннүгийн суурин «Гуа дов» нь жижигхэн шиг хайрхад байсан

¹ Бичурин, 1950, стр. 49

² Сүхбаатар., Жамсран, 1968, т. 10; Сүхбаатар, 1980, т. 73; Сүхбаатар, 1992, т. 24

байж магадгүй» гэж тайлбарлажээ. Мөн байрлалыг нь тодорхой заагаагүй ч хятад эрдэмтдийн Тамирын гол, Хархорум орчим гэсэн саналыг хоёр ч удаа тусгайлан цохож тэмдэглэжээ.³

Түүний бичсэн, тайлбарласнаас үзвэл, *нэгд* – Лунчэнийг Луу хот гэж орчуулжээ, *хоёрт* – суурин газар гэж үзсэн ч хүннүгийн улс төрийн төв гэж тайлбарлаагүй байна, *гуравт* – Лунчэн буюу Луу хот нь Хүннү улс нийтээр тахиж шүтдэг бөө мөргөлийн төв, *дөрөвт* – Лунчэн буюу Луу хотыг Хэрлэнгийн сав дахь Гуа довтой адилхан суурин байсан гэж төсөөлжээ, *тав* – Лунчэнийг Тамирын гол эсвэл Хархорум хавьд байрлалтай гэсэн хятад эрдэмтдийн саналыг бараг л дэмжжээ гэж дүгнэж болох юм.

Түүхийн тэмдэглэлийн «лун» (龍, *lóng, lǒng*) бол «луу» гэсэн үг биш болохыг эрдэмтэд аль эрт хэлсэн. Э.Пуллиблэнк, «Түүхийн тэмдэглэл»-ийн хүннүгийн *лунчэн*-ий «лун»-ыг хожмын хятадын судар тайлбарлагч нар «луу» гэсэн үг мөн гэж тайлбарлахыг оролддог. Тэгэхдээ, тэд *луу* нь хүннүгийн гол шүтээн байсан гэж үздэг. Гэвч «лун» бол «луу»-тай огт холбоогүй, ямар утгатай нь үл мэдэгдэх харь үг юм гэсэн дүгнэлтэнд Такигава (Takigawa Kametarō, 瀧川龜太郎. «Shiki kaichū kōshō, 史記會注考證», 110, p. 23) хүрсэн, эргэлзээнгүй түүний зөв гэж үзжээ. Улмаар харь үгийг тэмдэглэсэн учраас л хятад бичгийн хүмүүс «лун» гэсэн утга үсгийн дээр 'өвс' эсвэл 'хулс' гэсэн тэмдэг нэмж зурж хүннү үгийг галигласан гэж үзсэн байна.⁴

Түүхийн тэмдэглэлийн хүннүгийн бүлгийн 2896, 2897-д дурдах: *ланжун сиюйцян* (郎中係雫淺, *langzong xiuyuqian*) гэсэн хоршоо үгтэй, - *дахуй лунчэн* (大會龍城, *dahui longcheng*) гэсэн хоршоо үг - *байрлал* гэх утгаар бол *яг ижил*. Ланчжун бол арын залгаа *сиюйцян* гэсэн хүннү үгийн утгыг заасан, харьцуулж хэрэглэсэн нэр томьёо гэж харсан бид *сиюйцян*-г 'шийтгэгч/ланчжун' гэсэн утгатай гэсгээгч хэмээх хүннү үг гэж тайлбарласан, амжилттай болсон байх гэж найдаж байгаа.

'Дахуй' 'лунчэн'-ийг чухам үүн лүгээ ижил гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, *лунчэн*-ий өмнөх *дахуй* нь арынхаа хүннү үгийн утгыг зааж өгсөн орчуулга үг гэж харвал *лунчэн* нь 'хурах', 'цугларах'-ыг заасан л нэр томьёо болж байгаа юм. Г.Сүхбаатар «Монголчуудын эртний өвөг» зохиолынхоо «Нийгмийн байгуулал» хэмээх бүлгийн **Хуралдаан** гэсэн бичил хэсэгтээ *лунчэн*-ийг тайлбарласнаас⁵ ургуулан бодвол бидний баримталж буй санал зөв санагдана.

Тэгээд ч Түүхийн тэмдэглэлийн *лун* (龍, *long*) гэх утга үсэгт бидний төсөөлж буй агуулгыг илэрхийлэх утга байна.

Орчин цагийн толь бичгээр бол *лун* (龍, *long*) нь гурван утгатай. *Нэгд* (*lóng*), тарнын овгийн нэгэн зүйл ургамлын нэр (*polygonum orientale*) бөгөөд Монгол оронд ургадаггүй бололтой, *хоёрт* (*lóng*), 'ширүүн, догшин, омголон' бас 'өтгөн' гэх утгатай тэмдэг нэр гэж толь бичигт тэмдэглэсэн бол *гуравдахь* (*lǒng*) утга нь – 'цугларах, хуралдах, хурах, хүйлэх' гэсэн үйл заасан үг болох ажээ.⁶

Тэгэхээр 'хуралдах', 'хурах', 'хүйлэх' гэсэн утгатай утга үсгээр, дуудлага ойр хүннү үгийг галиглажээ, эртний *хятадууд* ингэж л харь үг галигладаг. Харин уул «лун, 龍»-г хожим «Хань улсын бичиг»-т дуудлага ижил «луу, 龍» хэмээх утгатай утга үсэг/ханзаар сольжээ.

³ Сүхбаатар, 1980, т. 36, 76-ийн тайлбар 1

⁴ Pulleyblank, 1962, p. 214; Пуллиблэнк, 1986, стр. 31

⁵ Сүхбаатар, 1980, т. 73-74

⁶ Большой китайско-русский словарь, 1984, № 12293

Түүхийн тэмдэглэлийн бичлэг/тэмдэглэгээ (лун, 龍, long)-г гол болгох аваас лунчэн-ийг «Луу хот» эсвэл «Луу суурин» гэж эсвэл бүр «Лүн» болгож шууд эдүгээчлэн монгол хэлнээ хэрэглэх явдал түүхийн баримтыг *ноцтой* гуйвуулж буй хэрэг мөн, чухам харийн судлаачдын үг хэллэгийн далд бодлогод автсан хэрэг. Дашрамд хэлэхэд, *шаньюй*-г ч мөн манай зарим судлаач, бичээч *чаньюй* гэж бичих ёстой хэмээн зүтгэх болоод удаж байна, гэвч *шаньюй* гэснийг нь хэрэглэх нь зөв болов уу, сүүлд бидний зөв, бурууг хятад хэлээр гүн мэргэшсэн гэж өөрсдийгөө нэрлэгч судлаачид хэлж өгөх байх гэж найдаж байна.

Лун-гийн талаар өгүүлсэн эхний хэсгээ хураангуйлж товчлох аваас, Түүхийн тэмдэглэлийн лун болбоос - хурах, цугларахыг заасан хэрнээ хүннү үгийн эхний үеийг галигласан үг; залгаад байгаа чэн гэх үг үндсэн 'суурин' гэх утгаараа бус шууд лун-гийн хамт хүннү нэр томьёоны дуудлагыг галигласан үгийн салшгүй бүтэц гэж үзмээр санагдана. Үүнийг, чухам Түүхийн тэмдэглэлийн лун(龍)-г «Хань улсын бичиг»-г лун(龍) гэж өөрчилсөн нь хожмоо олон төөрөгдлийн эх үүсвэр болжээ.

Одоо, хүннүгийн «лунчэн» гэсэн үгийн утгыг нэг мөр хоёрдмол утгагүй тодруулахад нэмэртэй баримтаас ганц нэгийг дурдъя.

Эхлээд, Түүхийн тэмдэглэлийн мөнөөх «五月大會龍城祭其先天地鬼神, wuyue dahui longcheng jiqi xian tian di guishen» өгүүлбэрийн шинэ буулгаварыг хэдэн хувилбараар толилуулъя. Үүнд, *нэг*, «таван сард их хурал/дахуй»-лунчэн хийж - дээдэс, тэнгэр газар, онго хайрхадаа тахидаг», эсвэл *хоёр*, «таван сард лунчэн [гэдэг] их хурлаар - дээдэс, тэнгэр газар, онго хайрхадаа тахидаг» эсвэл, *гурав*, «таван сарын лунчэнээр - дээдэс, тэнгэр газар, онго хайрхадаа тахидаг» гэж буулгаж болох мэт. Ингэвэл, хүннү хэлээр лунчэн гэж нэрлэдэг их хурлаа (дахуй) хийхдээ (ө.х. их хуралдайн үеэр) өвөг дээдэс, тэнгэр газар, онго хайрхадаа хүннүчүүд (үнэндээ хэрэгтээ тэдний ихэс язгууртнууд) тахидаг хэмээх утга бүрэн илрэх мэт.

Таван сар буюу зуны дунд сарын нохой өдөр болдог хурлын үеийн төрийн тахилгыг сурвалжууд онцолж бичсэнээс болж лунчэн-ийг хурал заасан нэр томьёо бус харин тахилга болдог газар хэмээн ойлгох болсон байх. Лав, де Креспиньи 1984 онд «the phrase *Longcheng*, written 龍城 or 龍城, obviously refers to a palace ...»⁷ гэж үзсэн байдаг. Энэ мэт андуурал хөвөрсөөр, хөгжсөөр бүр улсын нийслэлийг заасан үг болжээ гэдгийг цохон тэмдэглэе.

Лунчэн гэсэн хүннү үг нь орчин цагийн 'хурал', 'хуралдай'-тай ижил үгийн галиг болохыг нотлох баримт дотроос хамгийн тодорхой мэдээ, өмнөд хүннүгийн Туньгүхэ шаньюйн захидалд бий. Хожуу Хань улсын Суцзун хаан нас барсаны дараа төрийн эрх атгасан Доу хатанд долоон сард (м.э. 88.8.6-9.3) захидал илгээж, Умард Хүннүг мөхөөх төлөвлөгөө танилцуулахдаа Туньгүхэ (BX *tʷən.dā.γā < *tödögä), бүх аймаг було-д (?) гол дээр болох *есөн сарын лунцы* (龍祠) гэхэд цэрэг морио бэлтгэсэн байхыг тушааж мэдэгдсэн гэж өгүүлдэг.

Энэ мэдээг Э.Паркер «I have already commanded all the tribes to keep their men and horses well up to the mark, and to assemble on the [Yellow] River bank for the dragon sacrifices of the 9th moon» гэж орчуулсан бол, В.С.Таскин «Я уже приказал всем кочевьям готовить воино и лошадей, чтобы в девятой луне во время жертвоприношений в Лунчэне все собрались на берегу Хуанхэ» хэмээн буулгажээ.⁸

⁷ de Crespigny, 1984, p. 507 n. 15

⁸ Parker, 1894/1895, p. 266; Таскин, 1973, стр. 83

Э.Паркер болохоор, *луун тахилгын үеэр*; В.С.Таскин болохоор *Лунчэн-д тахилга өргөх цагаар*, тэгээд хоёулаа *Хатан голын эрэгт цуглар* гэж орчуулжээ.

Хоёр орчуулгаас харвал утга нь өөрчлөгдсөн мэт. Угтаа, нэр нь үл мэдэгдэх нэгэн голын эрэгт болох есөн сарын [нохой өдрийн] *лунцы/хурлын* үед өмнөд хүннүгийн бүх овог(було)-ийн цэрэг морь бэлэн цугларах ёстой гэж би тушааж мэдэгдсэн гэж буулгавал зохих юм шиг. Түүнчлэн, Түүхийн тэмдэглэлийн *лунчэн* (龍城, longcheng), Хань улсын бичгийн *лунчэн* (龍城, longcheng) хоёроо бодвол Хожуу Хань улсын бичгийн *лунцы* (龍祠) нь, гурван янз бичигдсэн энэ хүннү үгийн цаана, орчин цагт *хурал* гэж бичиж буй үгийн эртний хэлбэр нуугдаж байгааг илүү тод харуулахуйц сэргээгддэгийг урьдчилан хэлье.

Лунчэн бол *хуралдаан* болохыг гэрчлэх бас нэг мэдээ бий. Модунаас эхэлж тоолбол хүннүгийн арван нэг дэх хаан болох, Хюлюйцюаньской, Сюйлюйцюаньцзюй гэж Бичурин, Таскин нар галигласан, Паркер болохоор бараг л Хөлөгүнгү (Hülügwengü⁹) гэж буулгасан шаньюй 9 жил төр барьсан юм. Хаан болоод уламжлал ёсоор өмнөх шаньюйн хатдыг “асарч гэрлэх” ёстой ч тэрбээр нэг хатантай нь гэрлэлгүй үлдээжээ. Тэгэхэд нь Хуяньти шаньюйн “гологдсон” хатан хүннүгийн баруун жигүүрт хэдэн үе эцэн ван суусан Модуны удмын Туцитан вантай холбогдсон гэдэг. М.э.ө. 60 оны зуны дундуур, аргын тооллоор 7-р сарын аравдаар болсон ээлжит *лунчэн*-ий дараа хүннүгийн ноёд харьж буцахад, баруун эцэн ван Туцитан лугаа холбогдсон хатан түүнд сэм хэл өгч, асар хол бүү яв, хаан маш хүнд өвдсөн, тун удахгүй үхэх нь тодорхой буй заа гэж хэлүүлсэн гэдэг. Хатны хэлсэнээр Хөлөгүнгэ (Hülügwengü) шаньюй *лунчэн*-ий дараахан, хэд хоноод үхжээ.¹⁰ Эндээс харахад *лунчэн* бол яах аргагүй ноёд ихэс цугларч төрийн их бага, хэрэг хэлэлцэж тохироод, *лунчэн*-ий эхэнд нь, дундуур эсвэл төгсгөлд нь «тэнгэр газар, онго хайрхад, өвөг дээдсээ» тахидаг байсныг харуулж байна. Мөн *лунчэн* гэх нэр томъёогоор дан ганц тахилга үйлдэх зан үйлийг хэлж байна гэж ердөө ойлгож болохгүйг сайхь мэдээ дахин харуулж байна.

Түүхийн тэмдэглэлийн «лунчэн»-ий «лун»-ы эртний дуудлага нь «хүннү» гэх угсаатны нэрийн сэргээлттэй төстэй сэргээгдэх учиртай гэж Э.Пуллиблэнк цохон тэмдэглэсэн. Нэг ёсны «хүннү» гэсэн үгтэй ижил зарчмаар сэргээгдэх байх гэж харжээ.¹¹ Түүний таамаглаж хэлсэнийг бид ойлгохдоо лун гэх үгийн эртний дуудлагын сэргээлт «алтай» тэр дундаа «монгол хэлний» өвөрмөц эсвэл түгээмэл онцлог шинжийг заавал илэрхийлэх ёстой юм байна гэж ухварласан билээ. Нэр өндөр эрдэмтний үгээр халхавчилж асуудлыг “гүжирдэж” шийдэх гэсэн хэрэг огт биш гэдгийг цохон тэмдэглэе. Тэрбээр 1962 онд *хүннү* гэхийг *f᠋᠋᠋.na᠋᠋, *люаньти* гэх хааны/шаньюйн ургийн нэрийг *vlān.te᠋᠋ эсвэл *vlōn.te᠋᠋ гэж харин *лун* гэхийг *vl᠋᠋ гэж сэргээж байсан юм.¹² Хорин таван жилийн дараа 1986 онд ЗХУ-д орчуулж хэвлэсэн түүний өгүүллийн дагалт тайлбарт, харин, одоо Пуллиблэнк дээрх гурваас *хүннү*, *луаньди* хоёрыг *hwəng.nə; *hwrān.tej гэж, өмнөхөөс огт өөрөөр сэргээх болсон гэж уншигч нарт нэмэлт мэдээлэл болгон өгч, бичсэн байдаг.¹³ Урьд 1962 онд *v-*, *f-* гийгүүлэгчээр сэргээгдэж байсан үгсээс хоёрыг нь 1986 оны орчим

⁹ Parker, 1895, p. 51

¹⁰ Таскин, 1973, стр. 30

¹¹ Pulleyblank, 1962, p. 241; Пуллиблэнк, 1986, стр. 31

¹² Pulleyblank, 1962, pp. 240-241

¹³ Пуллиблэнк, 1986, стр. 65-66

*hw- гэж сэргээх болсоныг онцолж *тогтолцоо*, *зарчим* гэж харж, даган дууриах гэж Пуллилбэнкийн судалгаа-үгийг эшилсэн юм. Эртний хятад бичгийн мэргэд, хүннүгийн шаньюйн ургийг *люаньти* гэж галигласныг бүгд мэднэ, *лун*-гийн адил *л*- ээр эхэлж байгааг уншигч та анзаарах байх. Түүний эртний дуудлагын сэргээлтийг *лун*-гийн сэргээлтэнд зайлшгүй харгалзах ёстой гэдэг нь түүхч нарт ойлгомжтой үйлдэл гэж бодож байна. Дараах харьцуулалтыг харна уу.

	1962	1986
хүннү	*flōŋ.naɦ	*hwōng.ná
люаньти	*vlān.teɦ / *vlōn.teɦ	*hwrān.tej
лун	*vlōŋ	(*hwr<...>?)

Пуллилбэнкийн өгүүллийн дагалтад буй *люаньти*-н 1986 оны сэргээлтийг “шууд хуулвал” *лун* нь бараг *hwōŋ гэж сэргээгдэх магадлалтай ажээ. Түүний (ө.х. Э.Пуллилбэнкийн) зөв болох нь Бакстер, Сагар нарын хамтын цахим толь дахь утга үсгийн сэргээлтээс харагддаг. Тэнд бичсэнээр бол, хэд хэдэн *лун* үсэг эрт цагт, бараг бүгд шахуу өмнөө *k*- гийгүүлэгчтэй сэргээгджээ.

龍/龍/籠, long 城, cheng 祠, ci					
Пуллилбэнк «In the foreign original we once again probably have to do with a word related to the name Hsiung-nu.»					
Бакстер, Сагар	OC	*k.rʰoŋ	*deŋ	*lə	(82, 15, 20)
Шюслер	LH	*loŋ/lionŋ	*dzeŋ	*ziə	(12-15, 9-14, 4-53)
	OCM	*rōŋ/roŋ	*deŋ (or geŋ)	*s-lə	
Старостин	BX	*roŋ	*ʒ(h)eŋ	*zhə	(1562, 488, 707)
	3X	*roŋ	*d(h)eŋ	*lhə	

Эдгээрээс, *лунцы* (龍祠)-гийн эртний дуудлага OC *k.roŋ.lə < *k(u)ŋu.lə нь орчин цагт монгол-кириллээр ‘хурал’, ‘хуралдай’ гэж бичиж буй үгсийн эртний дуудлага-хэлбэрийн галиг гэж дүгнэх боломж олгож байна. Чухам, Хожуу Хань улсын бичигт тэмдэглэсэн *лунцы* гэх хэлбэрийн сэргээлт уул саналд өчүүхэн боловч боломж буйг ийнхүү илүү тодорхой харуулж байна.

Гарцаагүй харь (хүннү) үг гэж Такигава, Пуллилбэнк нарын үзсэн «лунчэн» гэсэн нэр томьёоны талаар товч өгүүлсэнээ хураангуйлбал:

нэгд, суурин газрын нэр биш болох нь тодорхой болов,

хоёрт, зуны дунд/таван сарын нохой өдөр болдог хүннү ноёдын их хуралдай (дахуй)-г ханьгийн бичгийн мэргэд *лунчэн/лунцы* гэж галиглажээ,

гуравт, «лунцы/лунчэн» бол орчин цагийн монгол-кирилл бичгээр *хурал*, *хуралдай* гэж тэмдэглэдэг үгийн эртний хэлбэрийн галиг юм байна, хэмээн үзэж болохоор болов.

Хожуу Хань улсын бичгийн мэдээтэй эл дүгнэлт маягийн санал маань бүрнээ нийцнэ. «Шицзи», «Хань шу» хоёроос ялгаатай нь тэнд, хаврын тэргүүн сард шаньюйн өргөөнд болдог ноёдын *бага хурал* (чан сяохуй), намрын *дайлинь* гэх их хурлыг (цю ... дахуй дайлинь) таван сарынхтай нийлүүлээд *хүннүчүүд* «... жилд гурван удаа, дандаа цагаан сар, таван сар, есөн сарын нохой өдөр хуралдаж, тэнгэр,

онгодоо тахидаг» гэж бичсэн билээ. Гурвуулаа, хүннүгийн хаад ноёд цугларч хуралдан хэрэг хэлэлцэж, хүн ам, мал сүргээ толж бүртгээд, дараа нь тэнгэр онго шүтээнээ тахидаг төрийн маш чухал арга хэмжээ «улсын их, бага хурал» болохыг «Хоу хань шу»-д илүү тодруулж тэмдэглэжээ.

Abstract

The article suggests that the xiongnu word “longcheng”, which most of modern researchers translate usually as “Dragon city”, is in fact a transcription of old form of the modern word “khural” or “khuraldai”. The author attempts to prove by written evidence that Longcheng was not a settlement with chanyu palace.

Ашигласан материал

1. Сүхбаатар., Жамсран, 1968 - Сүхбаатар Г., Жамсран Л. *БНМАУ-ын түүхийн дээж бичиг. I*. АБЯХ., УБ., 1968
2. Сүхбаатар, 1980 - Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал (МЭӨ IV – МЭ II зуун)*. ШУАХ., УБ., 1980
3. Сүхбаатар, 1992 - Сүхбаатар Г. *Монголын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр*. СБХН ХГ., УБ., 1992
4. Бичурин, 1950 - Бичурин Н.Я. *Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена*. Том I. Издательство АН СССР, Москва-Ленинград, 1950
5. Пулльблэнк, 1986 - Пулльблэнк Э.Дж. *Язык сюнну – Зарубежная тюркология*. Выпуск I. древние тюркские языки и литературы. Издательство «Наука», ГРВЛ., М., 1986
6. Таскин, 1973 - Таскин В.С. *Материалы по истории сюнну (по китайским источникам)*. Выпуск второй. Предисловие, перевод и примечания. Издательство «Наука», ГРВЛ., М., 1973 de Crespigny, 1984 - de Crespigny R. *Northern Frontier. The Policies and strategy of the Later Han Empire – FASM. NS. No4. FAS., ANU., Canberra, 1984*
7. Parker, 1894/1895 - Parker E. *The Turko-Scythian Tribes – The China Review. Vol. XXI, No. 4, 1895, pp. 253-267*
8. Parker, 1895 – Parker E.H. *A Thousand Years of the Tartars*. KWL., Shanghai, 1895
9. Pulleyblank, 1962 - Pulleyblank E.G. *The Consonantal System of Old Chinese. Part II. Appendix. The Hsiung-nu Language – Asia Major. NS. Vol. IX, 1962, p. 214*
10. Бакстер, Сагар - Baxter, W. and L.Sagart. *Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00)*. 2011 (цахим PDF толь)
11. *Большой китайско-русский словарь*, 1984 - Большой китайско-русский словарь. Том 4. Иероглифы № 10746-№15505. Издательство «Наука», ГРВЛ., М., 1984
12. Старостин - Китайские иероглифы. Составитель С.А.Старостин (цахим PDF толь), 1996
13. Шюсслер - Schuessler A. *Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Recensa*. UH Press, Honolulu, 2009